



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын гуравдугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СБА-2025/130/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2025 он	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Аудитор: Б. Бүзмаа Утас: 91160110 Цахим хаяг: Buzmaa@mindug.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	10
3.1 Албан шаардлага .....	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 163

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага нь 2024 онд батлагдсан улсын төсвөөс 1,091,863.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 59,859.8 мянган төгрөг, нийт 1,151,723.2 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсан.

Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийн дагуу 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээний хүрээнд:

- ✓ Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 102,332.3 мянган төгрөг, батлагдсан төсвийн санхүүжилтээр 1,151,723.2 мянган төгрөгийн орлого, нэмэлт санхүүжилтээр 6,070.0 мянган төгрөгийн төсвийг үйл ажиллагааны хувьсах зардалд 1,053,176.1 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 206,949.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэйгээр тайланд толилуулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудлыг тодорхойлоход материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ өндөр, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын шийдвэр гаргасан чухал асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал гараагүй болно.

## **Бусад асуудал**

Сүхбаатар аймгийн Боловсролын газрын даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг тайлант онд 10 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 88.7 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>176,499,857.63</b>	<b>307,028,048.48</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	102,332,279.63	206,949,342.28
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	102,332,279.63	206,949,342.28
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	102,332,279.63	206,949,342.28
31211	Төрийн сангийн харилцах	102,332,279.63	206,949,342.28
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	74,167,578.00	100,078,706.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	74,167,578.00	100,078,706.20
35460	Хүнсний материал	1,117,050.00	987,635.20
35470	Бусад хангамжийн материал	73,050,528.00	99,091,071.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>672,662,384.74</b>	<b>628,737,022.32</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	672,662,384.74	628,737,022.32
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	614,011,718.14	570,586,355.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	647,186,904.21	647,186,904.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,372,730.16	-121,820,639.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,485,905.00	52,485,905.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,295,255.32	-23,279,370.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,819,847.00	27,297,847.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,249,585.95	-15,739,226.79
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,770,000.00	5,706,340.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,242,666.64	-2,160,704.36
39217	Ном	909,300.00	909,300.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	58,650,666.60	58,150,666.56
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-833,333.40	-1,333,333.44
39303	Бусад биет бус хөрөнгө	57,984,000.00	57,984,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>849,162,242.37</b>	<b>935,765,070.80</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,869,900.00</b>	<b>1,410,700.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,869,900.00	1,410,700.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	4,869,900.00	1,410,700.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	56,800.00	440,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	4,813,100.00	970,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,813,100.00	970,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>844,292,342.37</b>	<b>934,354,370.80</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	844,292,342.37	934,354,370.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	189,364,077.15	189,364,077.15
51101	Өмч: - төрийн	189,364,077.15	189,364,077.15
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	275,891,818.77	365,953,847.20
51210	Өмнөх үеийн үр дүн	-146,486,400.01	275,891,818.77
51220	Тайлант үеийн үр дүн	422,378,218.78	90,062,028.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	379,036,446.45	379,036,446.45
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>849,162,242.37</b>	<b>935,765,070.80</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,182,353,870.00	1,165,399,540.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	343,542,370.00	7,606,340.00
120	Нийтлэг татварын бус орлого	343,542,370.00	7,606,340.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	343,542,370.00	7,606,340.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,300,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	338,242,370.00	7,606,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	838,811,500.00	1,157,793,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	732,763,700.00	1,091,863,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	732,763,700.00	1,091,863,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,070,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	106,047,800.00	59,859,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,047,800.00	59,859,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	759,110,878.81	1,075,337,511.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	759,110,878.81	1,075,337,511.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	752,335,357.44	1,074,927,883.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,118,034.63	687,596,733.87
210101	Үндсэн цалин	317,427,048.10	462,819,820.85
210102	Нэмэгдэл	128,172,989.55	194,465,333.02
210104	Урамшуулал	17,517,996.98	30,311,580.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,852,850.00	86,578,347.69
210201	Тэтгэврийн даатгал	40,213,224.83	59,711,155.80
210202	Тэтгэмжийн даатгал	4,730,967.59	7,043,755.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,841,891.32	3,577,681.91
210204	Ажилгүйдлийн даатгал	915,160.59	3,249,150.87
210205	Эрүүл мэндийн даатгал	9,151,605.67	12,996,603.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,789,942.74	91,422,291.60
210301	Гэрэл, цахилгаан	7,071,053.87	7,865,801.17
210302	Түлш, халаалт	68,574,608.03	69,121,203.43
210303	Цэвэр, бохир ус	8,144,280.84	14,435,287.00
2105	Нормативт зардал	91,939,797.90	110,469,092.60
210502	Хоол, хүнс	91,939,797.90	110,469,092.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,874,630.00	15,388,580.00
210604	Урсгал засвар	6,874,630.00	15,388,580.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,291,064.58	1,762,777.99
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,291,064.58	1,762,777.99

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,469,037.59	81,710,059.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,175,230.00	27,142,857.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,193,700.00	6,227,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,100,107.59	48,339,702.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,775,521.37	409,628.40
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,775,521.37	409,628.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,775,521.37	409,628.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	423,242,991.19	90,062,028.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	864,772.41	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	864,772.41	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-864,772.41	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	422,378,218.78	90,062,028.43

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>844,111,500.00</b>	<b>1,157,793,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,300,000.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,300,000.00</b>	<b>-</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	5,300,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,300,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>838,811,500.00</b>	<b>1,157,793,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>732,763,700.00</b>	<b>1,091,863,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	732,763,700.00	1,091,863,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>6,070,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>106,047,800.00</b>	<b>59,859,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,047,800.00	59,859,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>739,443,380.74</b>	<b>1,050,368,137.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>739,443,380.74</b>	<b>1,050,368,137.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>732,667,859.37</b>	<b>1,049,958,508.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>463,802,338.26</b>	<b>687,259,253.85</b>
210101	Үндсэн цалин	318,150,616.73	459,157,645.44
210102	Нэмэгдэл	128,133,724.55	194,410,006.47
210104	Урамшуулал	17,517,996.98	33,691,601.94
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>58,852,850.00</b>	<b>86,915,827.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,213,224.83	59,923,937.82
210202	Тэтгэмжийн даатгал	4,730,967.59	7,034,527.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,841,891.32	3,573,067.91
210204	Ажилгүйдлийн даатгал	915,160.59	3,276,898.87

210205	Эрүүл мэндийн даатгал	9,151,605.67	13,107,395.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>87,614,648.63</b>	<b>91,422,291.60</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,071,053.87	6,955,135.43
210302	Түлш, халаалт	68,574,608.03	69,121,203.43
210303	Цэвэр, бохир ус	11,968,986.73	15,345,952.74
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>92,937,697.90</b>	<b>110,396,477.80</b>
210502	Хоол, хүнс	92,937,697.90	110,396,477.80
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,587,630.00</b>	<b>34,989,880.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,000,000.00
210604	Урсгал засвар	7,587,630.00	24,989,880.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,291,064.58</b>	<b>3,262,777.99</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,291,064.58	3,262,777.99
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,581,630.00</b>	<b>35,712,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,552,130.00	25,933,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,029,500.00	9,778,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,775,521.37</b>	<b>409,628.40</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,775,521.37</b>	<b>409,628.40</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,775,521.37	409,628.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>104,668,119.26</b>	<b>107,425,062.65</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>10,410,000.00</b>	<b>2,808,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,410,000.00</b>	<b>2,808,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,410,000.00</b>	<b>2,808,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,410,000.00	2,808,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-10,410,000.00</b>	<b>-2,808,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>94,258,119.26</b>	<b>104,617,062.65</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>8,074,160.37</b>	<b>102,332,279.63</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>102,332,279.63</b>	<b>206,949,342.28</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.4	-146,486,400.01	421,914,123.59
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.4	-146,486,400.01	421,914,123.59
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	422,378,218.78	422,378,218.78
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.4	275,891,818.77	844,292,342.37
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.4	275,891,818.77	844,292,342.37
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.4	275,891,818.77	844,292,342.37
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	90,062,028.43	90,062,028.43
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.4	365,953,847.20	934,354,370.80

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,266,894,500.00	1,052,766,508.95
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,266,894,500.00	1,052,766,508.95
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,266,894,500.00	1,052,766,508.95
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	869,701,100.00	687,259,253.85
210101	Үндсэн цалин	619,909,300.00	459,157,645.44
210102	Нэмэгдэл	230,170,000.00	194,410,006.47
210104	Урамшуулал	19,621,800.00	33,691,601.94
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	99,490,800.00	86,915,827.71
210201	Тэтгэврийн даатгал	67,656,100.00	59,923,937.82
210202	Тэтгэмжийн даатгал	7,956,900.00	7,034,527.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,979,500.00	3,573,067.91
210204	Ажилгүйдлийн даатгал	3,979,500.00	3,276,898.87
210205	Эрүүл мэндийн даатгал	15,918,800.00	13,107,395.74
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	100,524,000.00	91,422,291.60
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	6,955,135.43
210302	Түлш, халаалт	74,827,600.00	69,121,203.43
210303	Цэвэр, бохир ус	17,696,400.00	15,345,952.74
2105	<b>Нормативт зардал</b>	114,951,800.00	110,396,477.80
210502	Хоол, хүнс	114,951,800.00	110,396,477.80
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,000,000.00	34,989,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	25,000,000.00	24,989,880.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,262,800.00	3,262,777.99
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,262,800.00	3,262,777.99
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	43,964,000.00	38,520,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,185,100.00	28,741,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,778,900.00	9,778,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,160,425,400.00	1,151,313,571.60
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,160,425,400.00	1,151,313,571.60
122005	Орон нутгийн төсвөөс	1,160,425,400.00	1,151,313,571.60
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	102,332,279.63
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	206,949,342.28

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн 3 алдаа зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1.4 сая төгрөгийн албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн. Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөх саналтай байна.

#### 3.1 Албан шаардлага

##### Илрүүлэлт:

Цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг 2 албан хаагчид нийт 1,402.0 мянган төгрөгийн цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг давхардуулсан олгосон зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 (харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1 (Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно), 12.1.4 (хуулиар зөвшөөрөөгүй бусад), Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан (Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын хавсралт), 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан (Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх) журмыг тус тус зөрчсөн байна.

#### 3.2 Зөвлөмж

##### 1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 37 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 (Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 (Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна), үүнд 6.2.1 (Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон), “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан тогтоох асуудлыг судлан, элэгдлээрээ бүрэн нөхөгдсөн хөрөнгийг ашиглалтын боломжит байдлыг харгалзан дахин үнэлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, Мөн шаардлагатай тохиолдолд Орон нутгийн өмчийн газартай зөвшилцөн данснаас хасах

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шийдвэрийг гаргуулах томьёолол бэлтгэн, санхүүгийн тайланд бодитой тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

## 2. Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээллийн 171 төрөлд хамаарах мэдээнээс 3 мэдээг хугацаанд нь байршуулаагүй нь мэдээллийн бүрдүүлэлт, хяналт хангалтгүй байсантай холбоотой байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.(тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх) заалтыг мөрдөж ажиллаагүй нь зүйд нийцэхгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол, шуурхай байршуулж, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах дотоод хяналтын тогтолцоог сайжруулан, хариуцсан албан хаагчдын хяналт, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урамшуулал болон нэмэгдэл цалинг олгохдоо тогтоол, дүрэм, журам баримтлаагүй	1	1,402.0			1	1,402.0		
Үндсэн хөрөнгөд үлдэх өртөггүй 17 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,402.0</b>			<b>1</b>	<b>1,402.0</b>	<b>1</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
3 мэдээг хугацаанд нь байршуулаагүй	1				1	
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>	